

ШИВЭЭГОВЬ СУМЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ /2023.06.25-2023.07.24/

УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Тулгар төрийн 2232 жил, Их Монгол Улсын 817 жил, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 112 жил, Ардын хувьсгалын 102-н жилийн ой, Үндэсний их баяр наадмыг суманд 2023 оны 07 дугаар сарын 10-ны өдөр тэмдэглэн өнгөрүүлж, Үндэсний бөхийн барилдаан, сурын харваа, Шагайн харваа, 3-н насны хурдан морь уралдуулсан. Бөхийн барилдаанд 64 бөх зодоглон барилдснаас:

Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын харъяат "Шивээ-Овоо ХХК"-ийн бөх Аймгийн харцага А.Тулга түрүүлж, Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын харъяат "Алтанбулаг" ХХК-ийн бөх Аймгийн арслан Б.Үүрцайх үзүүрлэсэн.





НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Нэг цэгийн үйлчилгээг операторын горимд шилжүүлснээр иргэд дараах үйлчилгээнүүдийг e-mongolia цахим системээс цаг алдалгүй авах боломжтой. 07 дугаар сарын байдлаар нийт 36 лавлагааг иргэдэд үзүүлсэн байна. Үүнд:

- Иргэний үнэмлэхний лавлагаа – 3
- Иргэний оршин суугаа газрын хаягийн бүртгэл лавлагаа – 5
- Нийгмийн даатгал шимтгэл төлөлтийн талаарх лавлагаа – 24
- Жолооны үнэмлэх солих, дахин авах – 1
- Иргэний үнэмлэх дахин авах – 1
- Шүүхийн шийдвэрээр бусдад төлбөргүй эсэх тодорхойлолт – 1
- Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тодорхойлолт - 1



БАЙГАЛЬ ОРЧНЫ ХҮРЭЭНД

Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд зам дагуух ногоон байгууламжийн мод, ойн зурвасын 4 га газрын мод бутыг хөдөлмөр халамжийн “Мод бут тарих ажлын хүрээнд 2023.07.17-ны өдрөөс эхлэн мод бутыг услах арчилах ажлыг 6 иргэнтэй гэрээ байгуулан тогтмол хийлгэж байна. Мөн Шинэлэг Шивээговь төслийн хүрээнд 6 иргэнтэй гэрээ

байгуулан, нийтийн эзэмшлийн зам талбайн хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулж байна.

Нийтийг хамарсан ажилд ажилласан 12 иргэнд өдөр бүр халдвар хамгааллын дэглэмийг баримтлан ажиллах хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгааг өгч, гарын үсэг зуруулан хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, амны хаалт өгсөн.



Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд, Ойн зурваст ус нөөцлөх сав хийлгэж байршуулах, усалгааны системийг шийдвэрлэх ажлын хэсгийг хуралдуулан 3 ААНБ-д үнийн саналыг хүргүүлсэн.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу БНАТ-1, БНАТ-2А маягтын дагуу 2024 оны БХНСАНЗ-х төлөвлөгөөг eic.mn цахим мэдээллийн санд шивэлтийг хийсэн.

Булаг уст цэгийн тооллогыг УГГХДТСГ-ын ажлын хэсэгтэй хамтран 2023 оны 07 дугаар сарын 18-ны өдөр 1, 2 дугаар багийн хэмжээнд зохион байгуулсан.



2 дугаар багийн нутаг дэвсгэрт зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эхлүүлж буй 1 ААН байгууллагын үйл ажиллагааг зогсоон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар болон экологийн цагдаагийн албанд шилжүүлсэн.



Иргэний гомдол мэдээллийн дагуу Шивээговь сумын 2 дугаар багийн нутаг Цагаан өндөрийн ард чулуу нүүж байсан 2 техник хэрэгсэлтэй, 8 иргэнийг саатуулан цагдаагийн байгууллагад шилжүүлэн шалгалтын ажиллагаа явагдаж байна.

Мөн зүйтийн талд зөвшөөрөлгүйгээр цайны газар нээж ажиллуулж байгаа газарт цагдаагийн байгууллагатай хамтран шалгалт хийхэд эзэнгүй байсан.



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2 ба түүнээс дээш жил дараалан ашиглаагүй иргэн, аж ахуй нэгж байгууллагын эзэмшлийн газруудад сумын Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 23-ны А/81 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн нэгж талбар тус бүрт хяналт шалгалт хийж, фото зургаар баталгаажуулсан. Мөн хяналт шалгалт хийсний дагуу ажлын хэсгийг хуралдуулж хийсэн ажлын талаар зөвлөлдөж үр дүнг дүгнэсэн.

Мөн Засаг даргын 2023 оны А/77 дугаар захирамжаар “Нийтийн биеийн тамирын талбай байгуулах ажил”, Засаг даргын А/78 дугаар захирамжаар “Хүүхдийн тоглоомын талбай байгуулах ажил”-ын үнэлгээний хороо байгуулж, тендерийн баримт бичгийг боловсруулан зарлаж “Нийтийн биеийн тамирын талбай байгуулах ажилд 1 компани үнийн санал ирүүлсэн боловч тендерийн баримт бичгийн шаардлага хангаагүй тул татгалзан ахин зарлахаар бэлтгээд байна.

Хүүхдийн тоглоомын талбай байгуулах ажилд 1 компани үнийн санал ирүүлсэн тендерийн баримт бичгийн шаардлага хангасан тул гэрээ байгуулан ажиллаж байна.

2023 оны аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх шивээговь сумын шинэ суурьшлын бүсэд худаг гаргуулах, ухаалаг систем суурилуулах ажил сумын нэрт багийн нутаг дэвсгэрийн 15 дугаар байрны зүүн урд талд хийгдэж байна.



Төсөв, төрийн сангийн талаар

Шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацааны дагуу оруулж байна.

Мөн сар бүр:

- Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл (Бүтэн жилээр,Хагас жилээр,Улирал бүр,Сар бүр)
- Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (Бүтэн жилээр,Хагас жилээр,Улирал бүр,Сар бүр)
- Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл (Бүтэн жилээр,Бүтэн жилээр,Хагас жилээр,Улирал бүр,Сар бүр)
- Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт

Тухай бүр:

- Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ зэрэг мэдээ тайланг тайлагнаж байна.

Сумын Засаг даргын тамгын газарт татварын пос машинаар иргэдэд үйлчилж, татварыг цахимаар бүрдүүлж байна. Орон нутгийн 15 нэр төрлийн татварын орлого бүрдүүлэхээс 14 хоногийн байдлаар Цалин түүнтэй адилтгах орлогын албан татвар, Газрын төлбөр, Хог хаягдлын үйлчилгээний төлбөр, Түгээмэл тархацтай АМНАТ, Хөрөнгө борлуулсны орлого гэх мэт татварын дансуудад орлого бүрдээд байна. ОН-ын татварын орлого гүйцэтгэлээр 133,072,780 төгрөг бүрдсэн байна.

Дансны дугаар	Дансны нэр	Орлогын ангиллын код	Орлогын нэр төрөл	Батлагдсан төсөв жилээр	Батлагдсан төсөв Тайлант үе	Гүйцэтгэлээр
100220300901	Гс.Ши Суутган-1	110001	Цалин түүнтэй адилтгах	1,707,993,400	992,600,000	130,030,000.00
100220300911	Гс.Ши Хувь хүний ОАТ	110002	Үйл ажиллагааны орлого	10,000,000	5,810,000	-
100220300912	Гс.Ши Хувь хүнээс суут.ОАТ	110008	Шууд бус орлого	-	-	-
100220300916	Гс.Ши. Иргэний эрх борлуулсны орлого	110002	Үйл ажиллагааны орлого	-	-	-
100220300917	Гс.Ши Малын албан татвар	113004	Малд ногдуулах албан татвар	30,000,000	20,000,000	-
100220300921	Гс.Ши ҮХЭХАТ	113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	297,000,000	148,500,000	-
100220300922	Гс.Ши Галт зэвсэг албан татвар	113002	Бууны албан татвар	1,070,000	630,000	-
100220300923	Гс.Ши Газрын ҮХЭХАТ	118101	Газрын төлбөр	-	-	-
100220300941	Гс.Ши Улсын тэмдэгтийн хураамж	118001	Улсын тэмдэгтийн хураамж	3,000,000	1,750,000	-
100220300943	Гс.Ши Газрын төлбөр	118101	Газрын төлбөр	171,680,000	85,800,000	18,770.00
100220300947	Гс.Ши Хог хаягдлын хураамж	118009	Хог хаягдлын үйлчилгээний төлбөр	18,000,000	10,500,000	24,000.00
100220300948	Гс.Ши Түгээмэл тархацтай АМНАТ	118006	Түгээмэл тархацтай АМНАТ	3,000,000	1,750,000	3,000,000.00
100220300962	Гс.Ши Иргэний ҮХХБАТ	110004	Хөрөнгө борлуулсны орлого	5,000,000	2,905,000	10.00
100220300975	Гс.Ши Хадгаламжийн хүүгийн орлого	110003	Хөрөнгийн орлого	20,000,000	11,620,000	-
100220300924	ИРГЭНИЙ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН АЛБАН ТАТВАР	113001	ҮХХАТ	-	-	-
НИЙТ				2,266,743,400	1,281,865,000	133,072,780

Хөдөө аж ахуйн талаар

Шивээговь суманд нийт 12 иргэн хүнсний ногоо тариалж байгаагаас 07 сарын 24-ний өдрийн байдлаар Шар лууван 0,5048 га-д, Шар манжин 0,5006 га-д, Хүрэн манжин 0,0087 га-д, Сонгино 0,211 га-д, сармис 0,3 га-д, Өргөст хэмх 0,036 га-д, Улаан лооль 0,038 га-д, Тарвас 0,0062 га-д Чинжүү 0,0076 га-д тус тус тариалаад байна.

2023 оны 07 сарын 07-ны өдөр Хоршоо хөгжүүлэх сангаас иргэн Б.Бадамдовжидод “Хоёрдогч түүхий эд дахин боловсруулах” чиглэлээр 65 сая төгрөгийн зээлийг олгохоор шийдвэрлэсэн.

Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн үлдэгдэлтэй 21 зээлдэгчийн 120,609,120.5 төгрөгийн зээлийн мэдээллийг тулган баталгаажуулж, Монгол банк руу илгээсэн.



2023 оны 06 дугаар сарын 29-ний өдөр сумын төвийн хэсэг, зүүн гэр байр, урд гэр байраар явж золбин нохой, муур устгах ажлыг эхлүүлсэн. Нийт 34 нохой 16 муурыг устгасан. Уг ажлыг Улаанбаатар хотын иргэн Б.Буд сумын Засаг даргын Тамгын газартай гэрээ байгуулан сумын хэмжээний золбин нохой, муур устгах ажлыг 2023 оны 6-р сарын 29-ний өдөр зохион байгуулж ажилласан. Ажилд хяналтаар сумын 1-р багийн Засаг дарга ажиллаж, нохой ихээр байршдаг байрлалыг гүйцэтгэгчид зааж устгуулсан. Мөн ажлын хэсэг 2023 оны 06 сарын 29-ний 17 цагт нохойг тоолж ачих, устгал хийхэд хяналт тавьж ажилласан.

Эрүүл мэндийн төв

❖ **Амбулаторийн үзлэг**

Энэ 07 дугаар сард нийтдээ 218 амбулаторийн үзлэг хийгдсэн бөгөөд үүнээс идэвхитэй хяналт 52, урьдчилан сэргийлэх үзлэг 46, нярайн гэрийн эргэлт 6 тус тус хийгдсэн байна.

❖ **Түргэн тусламжийн дуудлагын тоо хэмжээ, төрөл**

Түргэн тусламжийн нийт 32 дуудлага хийгдсэний алсын дуудлага 0, ойрын дуудлага 32 ирсэн байна. Үүнээс том хүн 15, хүүхэд 18 дуудлага бүртгэгдсэн бөгөөд хөхний эрт илрүүлэгийн үзлэг 12, умайн хүзүүний эрт илрүүлгийн үзлэг хийгдээгүй байна.

❖ **Стационарийн үйл ажиллагаа**

Энэ сард эмнэлгийн төвд хэвтэн эмчлүүлэгчид нийт 11 байсан бөгөөд үүнээс дотор эрхтнээр 11, хүүхэд 0, төрөлт 0, халдварт өвчнөөр хэвтэн эмчлүүлээгүй байна.

Сумын баяр наадмын 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрөөс 2023 оны 07 дугаар сарын 17-ныг хүртэл ЭМТ-ийн даргын 2023 оны 06.30-ны өдрийн “А10” тоот тушаал “Хариуцлагатай жижүүр томилох тухай” тушаалыг батлуулж ажилласан. Хариуцлагатай жижүүрт томилогдсон эмч, мэргэжилтнүүдэд ЭМЯ-ны 2023.07.03-ны өдрийн “Чиглэл хүргүүлэх тухай” 5/3105 тоотыг танилцуулж эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангаж ажиллах талаар танилцуулсан.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг тасралтгүй хангах чиглэлээр:

1. Хариуцлагатай жижүүр эмч, сувилагч нарын хуваар гаргаж батлуулсан
2. Яаралтай тусламжийн эм, эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдлыг хангасан
3. ЭМТ-ийн яаралтай тусламжийн дуудлага хүлээн авах утасны дугаар болон эмч нарын утасны дугаарыг ЭМТ-ийн PAGE хуудсанд байршуулсан
4. BVRTGEL.MOHS.MN программаар Эрүүл мэндийн яамруу илгээгддэг өглөөний мэдээг тасралтгүй ээлжийн сувилагч нэгтгэн илгээсэн
5. Эмнэлгийн түргэн тусламжийн машины бэлэн байдал, шатахуун зэрэг жолоочийн ээлжийн амралтыг зохицуулан бэлэн байдал ажиллуулсан
6. Тог тасарсан тохиолдол моторын бензин шатахууны нөөцийг бүрдүүлсэн

❖ **Сургалт, сурталчилгаа**

Шивээговь сумын Эрүүл мэндийн төвийн эрүүл мэндийн боловсрол олгох page хуудас болон шивээговь нэгдсэн зарын дээр ард иргэдэд эрүүл мэндийн мэдээ, нийгмийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан богино хэмжээний бичлэг зэргийг цаг алдалгүй оруулж ажиллаж байна. Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Хэвтэн эмчлүүлэгчдийн хоол хүнсний материалын хүрэлцээтэй байна. Эм тарианы хангалт хийгдсэн одоогийн байдлаар хүрэлцээтэй байна. 2023 оны сургалт сурталчилгаа төлөвлөгөөний дагуу мэдээ мэдээлэл, зөвлөмжийг цаг тухай бүрт нь олон нийтийн сүлжээгээр мэдээллэдэг.

Соёлын төв

Говьсүмбэр аймгийн баяр наадмыг 2023 оны 07 сарын 5, 6-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлсэнтэй холбогдуулан тус наадмаар сумын отог гэр барьж, ардын авьяастнуудын болон Шивээн ганхаа хамтлагийн тоглолтыг зохион байгуулсан.



Соёлын сэргэлт -2023 ажлын хүрээнд сумын ардын авьяастан болон Шивээн ганхаа 3,4,5 хамтлаг, мөн Говьсүмбэр аймгийн Соёл урлагийн газар, Боржигин чуулга, Хүүхэлдэй театр, Боржигин өв музей, Алтай хамтлаг зохион байгуулан оролцож ард иргэдэд соёлын үйлчилгээ үзүүлсэн.



МЭДЭЭГ БЭЛТГЭСЭН:

АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН
ЭРХЛЭГЧ

Б.УУГАНБАЯР

ХЯНАСАН:

ЗДТГ-ЫН ДАРГА

Д.ОТГОНЖАРГАЛ

